



2020 оны 11 дүгээр сарын 25
№44 /1146/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠬᠤᠷᠭᠠᠨ

ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



זיכרון

זיכרון המורה מן ימים

- זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים
- זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים

007070

067070

זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים

- זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים
- זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים

070707

067070

זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים

- זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים

706670

670707

זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים

- זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים

070707

707070

זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים

- זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים
- זיכרון המורה מן ימים קרובים וזיכרון המורה מן ימים רחוקים

067070

070707



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|-----------------------------------------------------------------------------------------------|------|
| 473. | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2307 |
| 474. | Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2317 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|------|-----------------------------------------------------------------------------------------|-------------------|
| 475. | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай | Дугаар 34
2319 |
|------|-----------------------------------------------------------------------------------------|-------------------|

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|------|-----------------------------------------|--------------------|
| 476. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 113
2321 |
|------|-----------------------------------------|--------------------|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | |
|------|--------------------------------|--------------------|
| 477. | Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 207
2322 |
|------|--------------------------------|--------------------|

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | |
|------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|
| 478. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн зарим хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 10
2330 |
|------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 11 дүгээр
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт:

“18.1.3.хуралдааны танхимыг орхин гарахыг үүрэг болгох;”

2/18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг:

“18.9.Зөрчил гаргасан гишүүнд хүлээлгэсэн хариуцлага нь нэгдсэн болон тухайн Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд хамаарна.”

3/39 дүгээр зүйлийн 39.30 дахь хэсэг:

“39.30.Гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналаа Байнгын хорооны хуралдааны анхны хэлэлцүүлгийн явцад татан авч болно.”

4/60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг:

“60.2.Байнгын хороо бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулна.”

5/61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэг:

“61.2.Нэгдсэн хуралдаан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг энэ хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-43.4-т заасан журмын дагуу явуулна.”

6/62 дугаар зүйлийн 62.16 дахь хэсэг:

“62.16.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг энэ хуулийн 42, 43 дугаар зүйлийн 43.1-43.4-т заасан журмын дагуу явуулна.”

7/109 дүгээр зүйлийн 109.10 дахь хэсэг:

“109.10.Ерөнхий сайдын мэдээллийг нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд өөрөө хийнэ. Хүндэтгэн үзэх шалтгаантай бол түүний томилсон Засгийн газрын гишүүн мэдээлэл хийж болно.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:

“9.1.Нэгдсэн хуралдаан долоо хоног бүрийн Пүрэв, Баасан гарагт 10.00-13.00, 14.00-18.00 цагт хуралдана. Гишүүд өглөө 9.00 цагаас эхлэн ирцэд бүртгүүлж, хуралдаанаар асуудал хэлэлцэхэд бэлтгэнэ. Товлосон асуудлыг ажлын цагт багтаан хэлэлцэж дуусаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар хуралдааны цагийг сунгаж болно.”

2/10 дугаар зүйл.Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг тогтоох журам

“10.1.Төрийн байгуулалтын байнгын хороо нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд, түр хороо, хууль санаачлагчийн саналыг үндэслэн дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл /цаашид “тогтоолын төсөл” гэх/-ийг боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална.

10.2.Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл болон батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан хууль, тогтоолын төслийг оруулна. Хэрэв нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй хууль, тогтоолын төслийг Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж болно.

10.3.Нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд, түр хороо, хууль санаачлагч нь дараагийн ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын талаарх саналаа чуулган дуусахаас ажлын 10 өдрийн өмнө Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн байна.

10.4.Нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд, түр хороо, хууль санаачлагч нь энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд санал ирүүлээгүй бол ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын талаар тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

10.5.Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль, тогтоолын төслийн хэлэлцэх дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга сар бүр захирамжаар батална.

10.6.Энэ хуулийн 10.5-д заасан дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаврыг Байнгын хороод баталж, мөрдүүлнэ.

10.7.Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулах асуудлыг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга шийдвэрлэнэ.”

3/18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэг:

“18.8.Энэ хуулийн 18.6-д заасны дагуу тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүн Улсын Их Хурлын болон гишүүний нэр хүндийг гутаан доромжилсон, эмх замбараагүй байдал үүсгэсэн болон бусад хэлбэрээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол хуралдаан даргалагч тухайн зөрчилтэй нь холбогдуулан уг гишүүний хуралдаанд оролцох эрхийг 3 хүртэл удаа хасаж болно.”

4/39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг:

“39.1.Холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нээлттэй болон хаалттай явуулж, холбогдох санал, дүгнэлт гаргана. Шаардлагатай гэж үзвэл Байнгын хороо төслийн тодорхой зүйл, хэсэг, заалтын талаар мэтгэлцээн явуулна. Хуралдаан даргалагч мэтгэлцээний хугацааг 60 минутаас илүүгүй байхаар тогтоох бөгөөд гишүүд саналаа чөлөөтэй илэрхийлэх боломж олгоно. Мэтгэлцээний хугацаа дуусмагц хуралдаан ердийн дэгээр үргэлжилнэ.”

5/62 дугаар зүйлийн 62.17 дахь хэсэг:

“62.17.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална.”

6/82 дугаар зүйлийн 82.2.8 дахь заалт:

“82.2.8.Цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан маргаантай асуудлаар Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэсэн дүгнэлт гаргасан бол уг



дүгнэлтийг Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр нэгдсэн хуралдаанд шууд танилцуулах бөгөөд санал хурааж шийдвэр гаргахгүй. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд тухайн асуудалд томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, үг хэлж болно.”

3 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “саад учруулж, хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахуйц нөхцөл байдал үүсгэсэн бол түүнийг хуралдааны танхимаас гаргана.” гэснийг “саад учруулах зэргээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахуйц нөхцөл байдал үүсгэсэн бол түүнийг тухайн асуудлыг хэлэлцэж дуустал хуралдааны танхимаас гаргана.” гэж, 18.6 дахь хэсгийн “энэ хуулийн 18.5-д заасан хариуцлагын хугацааг нэмэгдүүлэх үндэслэл болохыг хуралдаан даргалагч гишүүнд сануулна.” гэснийг “тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхийг хасах хариуцлага оногдуулах үндэслэл болно.” гэж, 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийн “24 цагийн” гэснийг “ажлын 2 өдрийн” гэж, 62 дугаар зүйлийн 62.15 дахь хэсгийн “найруулгыг” гэснийг “хэлэлцүүлгийг” гэж, 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсгийн “72” гэснийг “68-72” гэж, 88 дугаар зүйлийн 88.5 дахь хэсгийн “танилцуулна.” гэснийг “танилцуулах бөгөөд хоригийг шийдвэрлэсэн талаарх Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно.” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтын дугаарыг “18.1.4” гэж, 62 дугаар зүйлийн 62.16 дахь хэсгийн дугаарыг “62.17” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 11 дүгээр
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “Ерөнхийлөгч Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан үндсэн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачилна.” гэснийг “Ерөнхийлөгч энэ хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3-т зааснаас бусад асуудлаар хууль санаачилна. Ерөнхийлөгч хууль санаачлахдаа Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтална.” гэж, мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл” гэснийг “хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.11.1 дэх заалтын “эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл,” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 11 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр Хүрэлбаатарын Мөнхзул, Ганбатын Нарантуяа, Дугарын Сүнжид, Жаргалсайханы Хунан, Батзэвэгийн Энхболд нарыг тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Нанзадын Ганбаяр, Пүрэвийн Оюунчимэг нарыг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар 113

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах насанд хүрч, тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан шүүгч Бэгзийн Дамбыг Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Цэвэгдоржийн Оюунчимэгийг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Содовын Цэрэндуламыг Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 06 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 207

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.1.3, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.

3. Үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолыг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ё.БААТАРБИЛЭГ

Засгийн газрын 2020 оны 207 дугаар
тогтоолын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийн улс орнууд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг нийгмийн халамжийн бодлогын салшгүй нэг хэсэг болгож, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, мэдлэг чадвартай зөв хүн болгон төлөвшүүлэх, тэдний суралцах идэвх, оролцоог нэмэгдүүлэх, сурагчдын насны онцлогт тохирсон хоол, хүнсээр үйлчлэх, шим тэжээлийн мэдлэг, боловсрол олгох харилцааг хуулиар зохицуулан, тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж, сайн туршлагаудыг хуримтлуулсан байна.

Тухайлбал; Америкийн Нэгдсэн Улс 1946, Япон Улс 1954, Солонгос Улс 1953 оноос тус тус “Сургуулийн хоол”-ны тухай хуулийг хэрэгжүүлж эхэлжээ.

Америкийн Нэгдсэн Улсад өдөрт 31 сая, Японд 10 сая, Солонгост 7.3 сая, Энэтхэгт 140 сая, Оросын Холбооны Улсын бүх сургуулийн хүүхэд үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна.

Эдгээр улс орнуудын сургуулийн хоолны цэс нь өргөн сонголттой, хоолны түүхий эдийн 70 хувийг органик хүнс эзэлдэг байна.¹

Манай улсад “Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2006 оны 47 дугаар тогтоол, “Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоолын дагуу Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжиж байна.

Үндэсний аудитын газраас “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд уг хөтөлбөрт хамрагдаж байгаа сурагчдын 60 орчим хувийг хамруулж 2007-2008, 2010-2011 оны хичээлийн жилд судалгаа хийсэн бөгөөд уг судалгаагаар 2007-2008 оны хичээлийн жилийн бага ангийн сурагчдын 7 хоногийн дундаж ирц 91.3 хувьтай байсан бол 2010-2011 оны хичээлийн жилд 96.7 хувь болж өссөн байна.

Түүнчлэн сургууль завсардалтын байдлыг 16 аймгийн түвшинд авч үзэхэд 2006 оныг 2010 онтой харьцуулахад 54.9 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа талаар болон “Үдийн цай” хөтөлбөр нь нийслэлийн захын болон хөдөө орон нутгийн бага орлоготой өрхийн амьжиргаанд тодорхой хэмжээний дэмжлэг болж байгааг аудитын тайланд тус тус дурдсан байна.²

¹ Asia Pacific Journal of Clinical Nutrition, Volume 21, 2012

² Үндэсний аудитын газрын Үдийн цай хөтөлбөрийн явц, үр дүнгийн тайлан 2011

“Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон хүүхдэд халуун хоолоор үйлчлэхэд ажлын байр, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг стандартын шаардлагад нийцүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор шийдвэрлэх шаардлагатай байгаа тухай Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2019 онд цэцэрлэг, сургуулийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд хийсэн хяналт шалгалтын танилцуулгад тэмдэглэсэн байна.

Мөн танилцуулгад сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын хоол үйлдвэрлэлийн технологийн урсгал нэг чигийн бус, ялангуяа үдийн цайнд халуун хоол олгох болсонтой холбоотойгоор ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх хоолны газрууд хүчин чадлаасаа 5-10 дахин давсан ачаалалтай ажиллаж, хоол үйлдвэрлэлийн ажиллагаа бүгд нэг дор 30-40 м2 өрөөнд хийгдэж байгаа зөрчил нийтлэг илэрч, хоол, хүнс бохирдох, улмаар халдвар, хордлого гарах эрсдэлийг бий болгож байгаа тухай дурдсан байна.³

Эрүүл мэндийн яам, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангаас 2017 онд явуулсан “Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний V судалгаа”-ны дүнгээс үзэхэд илүүдэл жин, таргалалтын тархалт насанд хүрэгчид, сургуулийн хүүхэд, бага насны хүүхдийн дунд сүүлийн 10 жилийн хугацаанд эрс нэмэгдсэн байна.

Илүүдэл жин, таргалалттай хүүхэд насанд хүрэхэд зүрх судасны өвчин, багтраа, II хэв шинжийн чихрийн шижин зэрэг архаг өвчнөөр өвчлөх эрсдэл өндөр байдаг байна. Илүүдэл жинтэй 6-11 насны хүүхдийн эзлэх хувь хөдөө орон нутаг (17.6%)-тай харьцуулахад хот суурин газар (23.9%)-т өндөр байна.⁴

Иймд “Үдийн цай” хөтөлбөрийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас 2019 онд “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль”-ийг баталж, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийг Засгийн газар батлан, хэрэгжүүлэхээр заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний хуулийг дагаж гарах нийтлэг шаардлага, дүрэм, журмуудыг боловсруулан, хүнсний хангамжийн нэгдсэн тогтолцоог бий болгох, стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэж, оновчтой зохион

³ Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018-2019, 2019-2020 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын дүн

⁴ “Хоол тэжээлийн үндэсний V судалгааны тайлан” 2017 он, ЭМЯ, НҮБ-ын Хүүхдийн сан

байгуулах, суралцагчийн бие махбод, насны ангилалд тохирсон шим тэжээлийн зохистой харьцааг хангахад чиглэсэн хоолны жор технологийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулан, хоол, шим тэжээлийн талаар ойлголт, мэдлэг олгох тогтолцоог бүрдүүлэх, үр дүнг тооцож үнэлэлт дүгнэлт өгч байх зэрэг асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий үндэсний хөтөлбөрийг боловсрууллаа.

Үндэсний хөтөлбөр нь Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, үндэсний хөтөлбөртэй уялдан улсын төсөв, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж дэмжлэгтэйгээр үндэсний хэмжээнд хэрэгжинэ.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

2.1. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй, тогтвортой, хүртээмжтэй тогтолцоог бий болгох, суралцагчийг шим тэжээллэг хоол, хүнсээр хангаж, эрүүл мэндийг нь дэмжихэд энэ хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгуурласан, стандартын шаардлага хангасан хоол, хүнсний хангамжийн тогтолцоог бүрдүүлэх;

2.2.2. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх, хөндлөнгийн болон дотоод хяналтыг сайжруулах замаар хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах;

2.2.3. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

2.2.4. ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээр дамжуулан боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоол, шим тэжээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх.

2.3. Хөтөлбөрийг 2020-2025 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгуурласан, стандартын шаардлага хангасан хоол, хүнсний хангамжийн тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. орон нутгийн онцлогт тулгуурласан хүнсний хангамжийн тогтолцоог бий болгох, эрх зүйн орчныг сайжруулах;

3.1.2. сургууль дотор стандартын шаардлага хангасан ундны усаар үнэ төлбөргүй хангах нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.3. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хангамжид үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэх боломжийг бүрдүүлэх, органик болон баяжуулсан хүнсний сонголтыг нэмэгдүүлэх;

3.1.4. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах;

3.1.5. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махыг нийлүүлэх асуудлыг судалж, хэрэгжүүлэх;

3.1.6. суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд нийлүүлж байгаа хүнсний түүхий эдийг худалдан авах түүнд хяналт тавих цахим системийг газар зүйн байршил, орон нутгийн онцлогт тохируулан боловсруулах, турших.

3.2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх, хөндлөнгийн болон дотоод хяналтыг сайжруулах замаар хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавих дүрэм, журам, стандартыг боловсруулж, мөрдүүлэх;

3.2.2. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцсэн орчин үеийн, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах;

3.2.3. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байр, тоног төхөөрөмжийн хангамж, хүчин чадал, ашиглалтын талаар судалгаа хийж, үнэлэлт өгөх, бүртгэлжүүлэх;

3.2.4. зохистой дадал нэвтрүүлсэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах;

3.2.5. хүн амын зохистой хооллолтын зөвлөмж хэмжээ, үнийн өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан хоолны зардлын нормативыг тогтмол шинэчлэх, санхүүжилтийн уян хатан тогтолцоог бий болгох;

3.2.6. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүнсний хаягдлыг бууруулах, дахин ашиглах чиглэлээр инновацийн үйл ажиллагаа нэвтрүүлэх;

3.2.7. сургуулийн хоол, хүнсний болон орчны аюулгүй байдалд тандалт судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг холбогдох байгууллагатай хамтран үе шаттай зохион байгуулах.

3.3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



3.3.1. нутгийн захиргааны байгууллагад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх асуудал хариуцсан орон тооны ажилтантай болгох боломжийг судалж, эрх зүйн орчныг бий болгох;

3.3.2. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжлийн хүний нөөц бэлтгэж байгаа сургалтын тогтолцоог сайжруулах, дэмжих;

3.3.3. ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа хоол зүйч, тогоочийн мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын тогтолцоог сайжруулж, сургалтын байгууллагыг чадавхжуулах;

3.3.4. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллаж байгаа ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

3.4. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээр дамжуулан боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоол, шим тэжээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад олгож байгаа эрүүл мэндийн боловсролын хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэг олгох бүлгийн агуулгыг сайжруулж, модуль, хэрэглэгдэхүүн боловсруулах, турших;

3.4.2. багш, ажилчид, эцэг эх, асран хамгаалагчийн хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэх;

3.4.3. боловсролын үйлчилгээнд оролцогч талуудад хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэг олгох сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах, турших, сургалт зохион байгуулах;

3.4.4. сургуулийн хүүхдийн хоол, тэжээлийн байдлын судалгааг хийж шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах.

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, бүтээгдэхүүн,
шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1. орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоо бүрдсэн байна;

4.1.2. мэргэжлийн хүний нөөцөд суурилсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлснээр суралцагчид эрүүл, аюулгүй шим тэжээллэг хоол, хүнсээр тэгш, хүртээмжтэй хангагдана;

4.1.3. боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлснээр нийгмийн эрүүл мэндийн зарим үзүүлэлт дээшилсэн байна. Суралцагчдын хоол, шим



тэжээлийн эерэг ойлголт, мэдлэг нь гэр бүлийн түвшинд дам нөлөө үзүүлэх боломж бүрдэнэ;

4.1.4. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжсөнөөр шинэ ажлын байр бий болж, орон нутагт иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл бүрдсэн байна.

4.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр тодорхойлно:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2019 он)	Зорилтот түвшин (2025 он)
1.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах эрх зүйн баримт бичгийн тоо	тоо	0	12
2.	Сурагчдыг стандартын шаардлага хангасан ундны усаар үнэ төлбөргүй хангасан сургуулийн эзлэх хувь	хувь	56	100
3.	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэж байгаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх орон нутгийн болон дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь	хувь	15	60
4.	Үдийн хоолонд бүрэн шилжсэн сургуулийн эзлэх хувь	хувь	20	100
5.	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар нэгдсэн мэдээллийн сан бүхий цахим систем	тоо	0	1
6.	Хоол зүйчээр хангагдсан сургуулийн тоо	тоо	7	600
7.	Мэргэжлийн тогоочоор хангагдсан сургуулийн тоо	тоо	99	662
8.	6-11 насны хүүхдийн өсөлт хоцролтын тархалтын хувь	хувь	7.3 (2017 он)	5.0



9.	Хоол, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хийх нэвтрүүлгийн тоо	тоо	1	25
10.	Боловсролын үйлчилгээнд оролцогч талуудад зориулсан хөтөлбөр, хэрэглэгдэхүүн	тоо	0	3

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. гадаадын зээл, буцалтгүй тусламж;

5.1.3. олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.4. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;

5.1.5. бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, дүнг Засгийн газарт танилцуулна.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэлийн Засаг дарга удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаж, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн IY улиралд багтаан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

6.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг холбогдох яам, агентлагууд жил бүрийн 12 дугаар сард багтаан гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний болон хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2020 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай
хуулийн 9.6 дугаар зүйлийн зарим хэсэг
Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн
эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 13.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ц.Нанзаддорж даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү /илтгэгч/, Г.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Мөнхгэрэлийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн О.Баясгалан, Г.Нацагдорж нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 1, 2, 4, 6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны оршин суугч, иргэн О.Баясгалан болон Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Нацагдорж нар Үндсэн хуулийн цэцэд хандаж ижил агуулга бүхий мэдээлэл ирүүлжээ. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлд гэрчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон бөгөөд уг зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ.”, 2 дахь хэсэгт “Гэрч шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.”, 3 дахь хэсэгт “Гэрч дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг шүүхийн шийдвэрээр

албадан ирүүлнэ.”, 4 дэх хэсэгт “Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”, 5 дахь хэсэгт “Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.”, 6 дахь хэсэгт “Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй.”, 8 дахь хэсэгт “Шүүх, прокурор, мөрдөгч мэдүүлэг авахаас өмнө гэрчид энэ хуульд заасан гэрчийн эрх, үүргийг тайлбарлаж өгнө.” гэж тус тус хуульчлан заажээ. Мөн хуулийн 7.1 дүгээр зүйлд яллагдагч гэж хэн болохыг хуульчлан заасан байх бөгөөд 1 дэх хэсэгт “Энэ хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч гэнэ.” гэж заажээ.

Энэ хуулийн II хэсэг буюу “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогч” гэсэн хэсэгт сэжигтэн гэсэн ойлголт байхгүй бөгөөд хууль сурталчлах, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжсэн байдлыг үзвэл гэрчээс шууд яллагдагч болж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлж байна. Гэрч нь тухайн хэрэгт биечлэн шууд ба шууд бусаар оролцоогүй, хувийн ашиг сонирхолгүй байх бөгөөд тухайн хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг хэлнэ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаар гэрч шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг шүүхийн шийдвэрээр албадан ирүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэсэн үүрэг хүлээсэн этгээд билээ. Гэтэл тухайн хэргийг үйлдсэн этгээд гэж үзэгдэж буй этгээд нь өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй болохыг Улсын Их Хурал анхаараагүй байна. Мөрдөгч гэмт хэргийг шалгаж байхдаа гэрчийн өгсөн мэдүүлэгт буюу өөрийнх нь өгсөн мэдүүлэгт үндэслэн хэргийг илрүүлж түүнийг яллах талын нотлох баримт болгох эрх зүйн үндсийг хуулиар бий болгожээ. Мөн дээрх заалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараах наад захын баталгаагаар хангагдах эрхтэй.” гээд (g)-д “өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй,” байх гэсэн заалтыг зөрчсөн байна.



Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг батлан гаргахдаа энэ ажиллагаанд оролцогч төрийн тусгай албан хаагчид нь шударга ёсны зарчмыг хангах боломжгүй хууль баталсан байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, эрх чөлөө, ...-г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ... эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. ...” гэснийг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарт:

“1.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, ... эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. ...” гэж заасан бөгөөд 2017 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлээр энэхүү эрхийг Үндсэн хуульд тусгасан агуулгаар нь гэрчид олгосон зохицуулалт болсон юм. Тодруулбал, гэрч хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөвөөр мэдүүлэх үүрэгтэй хэдий ч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, хэрэв өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхийг гэрчид олгосон буюу гэрчийг хамгаалах зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан юм.

Өөрөөр хэлбэл, өмнө үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд гэрч өөрийн эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг тусгаагүйгээс үүдэн олон сөрөг үр, дагавар гарч байсныг засан сайжруулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчийн эрхийг хамгаалах асуудлыг баталгаажуулсан зохицуулалт болсон юм. Мэдээлэл гаргагч нь Монгол Улсын нэгдэн орсон гэрээг буюу Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын заалтыг дурдсан байна. Тус баримт бичгийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн (е)-д “өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаалгах буюу байцаалгуулах, эсрэг гэрчтэй адил нөхцөлөөр өөрийн өмнөөс гэрч оролцуулах болон шалгуулах;”, (g)-д “өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй;” байх гэж заасан бөгөөд оролцогч улсууд тус тусын хууль тогтоомжоор уг эрхийг баталгаажуулах үүрэгтэй. Энэ ч үүднээс Улсын Их Хурлаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд уг эрхийг баталгаажуулах зохицуулалтыг бүрэн хэмжээгээр тусгаж гэрч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, гэрчийн өөрийнх нь эсрэг мэдүүлэг авч байна гэж үзвэл өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй байхаар хуульчилсан юм.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд оршдог. Түүнчлэн хэргийг шалган шийдвэрлэх ажиллагааг зөвхөн хуульд заасан арга, хэрэгслээр явуулдаг төдийгүй нэг л хууль зөрчсөн үйлдэл гаргавал хэрэг шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримт нотлох чадвараа алддаг маш нарийн үйл ажиллагаа байдаг.

Хүнийг тодорхойгүй үндэслэлээр сэжиглэн сэжигтнээр тооцдог, үүрэг хүлээлгэдэг, албадлага хэрэглэн хүний эрхэнд хязгааргүй халддаг явдлыг таслан зогсоох зорилгоор хүнийг шууд сэжигтнээр тооцох бус эхлээд гэрчээр асууж нөхцөл байдлыг тодруулж, үүнтэй холбоотой мөрдөн шалгах ажиллагаа явуулж баталгаажуулсны дараа сэжигтнээр тооцдог болох, шаардлагатай бол албадлага хэрэглэх, эрх хязгаарлах арга хэмжээ авдаг байх нь хүний эрхийг хангах баталгаа болох юм байна гэж хууль тогтоогчид үзэж, ийнхүү хуульчилсан болно. Энэ нь аливаа хүнийг нотолгоогүй шууд сэжигтнээр тооцож мөрдөгч нар өрөөнийхөө үүдэнд уях, оргон зайлж болзошгүй гэсэн хардлагаар баривчлах зэрэг хүний эрхэд үндэслэлгүй халдах сөрөг байдлыг таслан зогсоохоос гадна хэрэг хийгээгүй байх хэрэг хийсэн мэтээр ойлгогдож, нэр төр алдар хүндэд нь



хохирол учрах, сэтгэл санааны дарамтад ордог олон сөрөг үр дагаврыг шийдвэрлэсэн зохицуулалт болсон гэж хууль тогтоогч үзэж байна.

Урд өмнө нь гэмт хэрэг гарсан тохиолдолд хэргийн газар байсан бүх хүмүүсийг сэжигтэн хэмээн эрхийг нь хязгаарлаж байгаад хэрэг шалгах ажиллагаа явуулж, хүний эрхийг бүдүүлгээр зөрчдөг байсныг таслан зогсоож, тухайн хүмүүсийг гэрчээр асууж, нөхцөл байдлыг тодруулах зорилгоор мэдүүлэг авдаг дэвшилтэт зохицуулалт болсон юм. Харин мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдсанчлан гэрчээр асуудгийг болиулж сэжигтнээр байцаадаг өмнөх зохицуулалтыг сэргээвэл дээр дурдсан хүний эрхийг зөрчдөг байдал эргэн сэргэх бодит нөхцөл үүснэ гэж үзэж байна.

Гэрчээр мэдүүлэг авч байх явцад тухайн хүн өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгч эхэлбэл мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан эрхийг сануулах ёстой бөгөөд ийнхүү эрхийг нь тухайн үед сануулаагүй бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтад тооцохгүй болох талаар гэрчийг хамгаалсан хуулийн зохицуулалтыг давхар хуульчилсан болно. Түүнчлэн гэрч мөрдөн шалгах ажиллагааны үед, шүүхэд үнэн зөв мэдүүлэг өгөхөө илэрхийлж баталгаа гаргасны дараа л худал мэдүүлэг өгсөн тохиолдолд хариуцлагын зохицуулалт ажиллахаар буюу Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд “Худал мэдүүлэх” гэмт хэргийг хуульчилснаар баталгаажиж байгааг дурдъя.

Хуулиар гэрчид олгосон мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг нэг мөр хангах үүднээс гэрчид хариуцлага тооцох үндэслэл болох 9.6 дугаар зүйлийн 4 дэх хэсгээс “мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн” гэснийг хасаж, “Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж өөрчлөн 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан.

Эцэст нь, мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн бус харин Үндсэн хуулиар олгосон эрхийг баталгаажуулахаас гадна хууль сахиулагчид хуулийг нэг мөр ойлгохгүй, хэрэгжүүлэхгүй алдаа, завхрал гаргаж байсныг шийдвэрлэсэн дэвшилттэй зохицуулалт болсон гэж үзэж байна. Иймд дээр дурдсаныг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйл Монгол

Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр хүргүүлж байна.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарт:

“... Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ.” гэж зааснаас үзэхэд гэрч нь заавал тухайн хэрэгт биечлэн шууд болон шууд бусаар оролцоогүй хүн байх шаардлагагүй байна. Түүнчлэн тухайн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйд ямар нэгэн байдлаар оролцсон хүн гэрчээр мэдүүлэг өгөх тохиолдолд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, мөн өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл мэдүүлэг өгөхөөс татгалзах, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй байхаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт зохицуулжээ. Энэ зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ... эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. ...” гэсэнтэй нийцсэн байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэхийг хориглоно.”, 9.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “Шүүх, прокурор, мөрдөгч мэдүүлэг авахаас өмнө гэрчид энэ хуульд заасан гэрчийн эрх, үүргийг тайлбарлаж өгнө.”, 16.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Дараах хүнээс гэрчийн мэдүүлэг авч болохгүй.” гээд 4.6 дахь заалтад “өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан гэрч, хохирогч.”, 16.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг ... бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь, ... нотлох баримтаар тооцохгүй байх тухай прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг шүүх хянан хэлэлцэж, ... шийдвэр гаргана.”, 16.14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ ... мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно.”, 25.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Мөрдөгч

мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлах ..." гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан хүний эрхийг баталгаажуулсан, нөгөө талаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн зүгээс хүний эрхийг зөрчихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн зохицуулалтууд юм.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдсэн нь тодорхой хүний өмнө нь гэрчээр өгсөн мэдүүлгийг нотлох баримтын хэмжээнд үнэлэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан, өөрийнх нь эсрэг яллах нотлох баримт болгон ашиглах явдал зарим хууль хэрэгжүүлэгч нарын үйл ажиллагаанд гарч байгаа нь хуулийн үзэл баримтлалыг бүрэн гүйцэд ойлгоогүй, хэвшиж тогтсон ажлын арга барилаа өөрчилж чадахгүй байгаа, хайнга хариуцлагагүй үйл ажиллагаатай нь холбоотой бөгөөд үүнийг хууль тогтоомжид заасан арга хэрэгслээр таслан зогсоох, зөвлөмж, чиглэл, сургалтаар засаж өөрчлөх бүрэн боломжтой гэж үзэж байна." гэжээ.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2020 оны 85 дугаар тогтоолын дагуу шинжээчээр томилогдсон доктор (Ph.D), профессор Т.Оюунчимэг дүгнэлтдээ:

"1. Эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухаанд "гэрч" хэмээх нэр томъёоны хүлээн зөвшөөрөгдсөн агуулга нь "эрүүгийн хэргийг мөрдөн шалгаж, хэргийг үнэн зөв хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа, үнэн зөв мэдүүлэг өгөх чадвартай, мэдэж байгаа зүйлийнх нь талаар мэдүүлэг авахаар дуудагдсан, аман мэдээлэл өгч байгаа ямар ч хүнийг гэрч" гэх бөгөөд энэхүү агуулга нь дэлхийн улс орнуудад нийтлэг байдлаар хэрэглэгддэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "Иргэн нь өөрийнхөө болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ..." буюу дуугүй байх эрхтэй гэж заасан. Хүн өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх нь тухайн хүний субъектив эрх учраас тухайн этгээдийн сонгох боломж гэж үзэж болно. Харин тухайн иргэн гэрчийн мэдүүлэг өгөх нь өөрийн сонголтыг хийж байгаа төдийгүй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох оролцогчийн эрх зүйн тусгай байдал бий болж, үнэн зөв гэрчлэх хууль зүйн үүрэг хүлээнэ. Тодруулбал, өмнө үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд "Гэрчийг тухайн хэрэгт оролцоогүй, хувийн сонирхолгүй байх." гэсэн шинжүүдийг эрүүгийн байцаан шийтгэх

ажиллагааны бусад оролцогчдоос ялгагдах шинж болгон үзэж байсныг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хасаж, эрүүгийн процессын эрх зүйн нийтлэг чиг хандлагад нийцүүлэн “Эрүүгийн хэргийг үнэн зөв хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар мэдэж, мэдүүлэг өгч байгаа хүн бүр гэрч.” гэсэн эрүүгийн процессын эрх зүйн нийтлэг үзэл баримтлалын жишгээр шинэчлэн тодорхойлжээ.

2.Гэрчээс мэдүүлэг авахын өмнө гэрчийн эрх буюу Үндсэн хуулиар баталгаажсан “Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх” эрхийг болон мэдүүлэг өгсөн тохиолдолд “Үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй” болохыг тайлбарлан өгөх, эрх үүрэгтэйгээ танилцсан тухайгаа баталгаажуулан гарын үсэг зуруулдаг нь гэрч сонгох эрхээ эдэлж буйн нотолгоо тул, тийнхүү авсан гэрчийн мэдүүлэг нь Үндсэн хуулийн болон олон улсын гэрээ конвенцыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна. Харин ийнхүү баталгаа гаргасны дараа зориуд худал мэдүүлэг өгсөн болох нь тогтоогдсон нөхцөлд гэрчийн эрх зүйн байдал бүрэн өөрчлөгдөх хууль зүйн үр дагаврыг дагуулдаг жишиг аль ч улс оронд нийтлэг байдлаар хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, гэрчийн өгсөн мэдүүлгийг тухайн этгээдийн эсрэг ашиглаж яллах боломжтой. Харин гэрчээс өөрийнх нь болон гэр бүлийн гишүүдийнх нь эсрэг мэдүүлэг гаргуулахаар шаардах, шахалт үзүүлэх, хүч хэрэглэсэн бол Үндсэн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн буюу тийнхүү гаргаж авсан гэрчийн мэдүүлэг нотлох баримтын чадвараа алдаж, шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй төдийгүй мэдүүлэг авсан этгээдэд хариуцлага хүлээлгэх үндэслэл болно. Эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухаанд “хязгаарлалт” гэдэг нэр томъёог хэрэглэдэггүй, харин хуулийн хүрээнд аливаа зүйлд хязгаарлалт тогтоох боломжтой.

Тодруулбал, гэрчийн хувьд өгсөн мэдүүлгийг тухайн этгээдийн эсрэг ашиглаж, яллах нотлох баримтад тооцох боломжтой эсэх талаарх хязгаарлалт, уг хязгаарлалтын онолын үндэслэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дээр дурдсан зохицуулалтаар хөндөж буй эсэх гэсэн асуулт нь гэрчийн иммунитетийн талаар тавьсан асуулт гэж ойлгож дараах байдлаар тайлбарлаж байна. Иммунитет буюу (immunitas) гэсэн нэр томъёо нь гэрч мэдүүлэг өгөхөөс чөлөөлөгдөх эрх буюу гэрчлэхээс чөлөөлөгдөх онцгой эрх тодорхой этгээдийг гэрчээр байцаахыг шууд хориглох тухай асуудал юм. Гэрчийн иммунитет эрхийг бүр эртнээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж иржээ. Иммунитет буюу онцгой эрх эдлэх эрх бүхий субъектүүдийг олон улсын нийтлэг жишгийн дагуу Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор баталгаажуулсан



байдаг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд иргэн нь өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллагдагч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруугүйгээ болон хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээхгүй буюу дээрх байдлын талаар мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй, гэрч нь өөрийн болон гэр бүлийн гишүүн, эцэг эх, үр хүүхдүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, тийнхүү мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй хэмээн бэхжүүлжээ. Нийтийн эрх зүйн тогтолцоо бүхий орнуудын орчин үеийн хууль тогтоомжид гэрчийн иммунитетийн хоёр төрөл үйлчилж байна. Нэгд, энгийн иммунитет (use immunity) нь хууль тогтоомжид нийтлэг байдлаар заасан иммунитетийг ашиглаж байгаа хүмүүсийн хүрээнд үйлчилдэг. Иммунитетийн энэ төрөл өөрийгөө яллахаас чөлөөлөгдөх тусгай эрх болон нууцтай холбоотойгоор бий болдог. Хоёрт, хэлцлээр үүсэх иммунитет (transaction immunity) нь мэдүүлэг өгөхөөр харилцан тохиролцсоны үндсэн дээр прокуророос тусгайлан олгогддог.

Энэ тохиолдолд тухайн мэдүүлэг өгсөн этгээдийг түүний шалгагдаж байгаа гэмт хэрэгтэй нь холбогдуулан “эрүүгийн хариуцлагад татаж болохгүй” гэсэн журам үйлчилж байна. Гэрчийн иммунитетийн дээрх хоёр төрөл нь манай улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой хэмжээгээр баталгаажсан байна.” гэсэн байна.

Тав. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад мэдээлэл гаргагч иргэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйл бүхэлдээ Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн мэдээллийн шаардлагаасаа татгалзаж, уг хуулийн 9.6 дугаар зүйлийн 1, 2, 4, 6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, мөн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэхийг тогтоолгохоор мэдээллийн шаардлагаа өөрчилсөн болно.

ҮНДЭСЛЭЛ:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “гэрч” гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг ойлгохоор тодорхойлсон нь эрүүгийн процессын эрх зүйд болон бусад улсын энэ талаарх зохицуулалт, нийтлэг жишигт нийцсэн зохицуулалт байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах,

... эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. ..." гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр шинэчлэн баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн "Гэрч" гэсэн 9.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт Үндсэн хуулиар баталгаажсан энэхүү эрхийг мөн тусган хуульчилсан байна. Тодруулбал, хуулийн дагуу гэрчээс мэдүүлэг авахын өмнө Үндсэн хуулиар баталгаажсан эрх болох "Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх" буюу "дуугүй байх" эрхийг мэдүүлэг авах эрх бүхий этгээд гэрчид тайлбарлан өгөх үүрэгтэй байхаар заажээ. Мөн тус зүйлийн 6 дахь хэсэгт гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй байхыг хуульчилж, Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг баталгаажуулсан байна.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Гэрч шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.", мөн зүйлийн 4 дэх хэсэгт "Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гэсэн гэрчийн үүргийг хуульчилсан зохицуулалт нь эрүүгийн процессын эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг зохицуулалт байх бөгөөд Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг үндэслэлгүй хязгаарласан шинжгүй, хууль зүйн процессын суурь зарчмуудад нийцсэн байх ёстой. Энэ утгаараа хуульд гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг дээрх хуулиар нарийвчлан зохицуулж өгөөгүйн улмаас тухайн этгээдээс гэрчийн мэдүүлэг авч, түүний эрхийг хөндөх байдал гаргахаар байгааг хууль тогтоогч анхаарч, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн иргэнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэргүүн ээлжид танилцуулж, мэдүүлэг өгөх тохиолдолд худал мэдүүлбэл хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг сануулах журмыг илүү тодорхой хуульчлах нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС
ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 1, 2, 4, 6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ... эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**Ц.НАНЗАДДОРЖ
Д.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ
Г.БАЯСГАЛАН**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 200003